



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.10 № 01/5805
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамжийн дагуу тус байгууллагад ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар холбогдох зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр зохих арга хэмжээг авч Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан дагуу хариуг 2023 оны 2 дугаар улиралд гүйцэтгэл, үр дүнг нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142303005706



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.10 № 01/5805
танай _____-ны № _____-т


Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамжийн дагуу тус байгууллагад ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар холбогдох зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр зохих арга хэмжээг авч Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан дагуу хариуг 2023 оны 2 дугаар улиралд гүйцэтгэл, үр дүнг нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142303005706

Авлигатай тэмцэх газрын
2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн
01/5808 дугаар албан бичгийн хавсралт

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Экспорт, импортын лиценз олгох, хяналт тавих төрийн байгууллага хоорондын уялдааг хангах, мэдээлэл солилцох ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх

Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоол "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-ыг хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, мэдээлэл солилцоо цахимд бүрэн шилжээгүй учир хүнд суртал, чирэгдэл үүсгэх, авлига, ашиг сонирхлын зөрчил бий болох эрсдэлтэй байна.

Тухайлбал: Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/407 дугаар тушаал "Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам"-ын 2 дугаарт Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын дагуу олгосон лицензийн мэдээллийг Гаалийн ерөнхий газарт улирал бүр хүргүүлж байхыг даалгасан бөгөөд, гаалийн байгууллагад дээрх үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийн сан байхгүй, импортын барааг салбар болон бүтээгдэхүүн тус бүрээр өөр өөр чиглэл хариуцаж, нэгдсэн зохицуулалт болон хяналтгүй байна;

Түүнчлэн 2018-2022 онд төрийн хяналтын дор нэвтрүүлэх "булчирхай болон бусад эрхтний ханд, тэдгээрийн ялгарал, шүүрлийн ханд", "донорын цус, бичил биетний өсгөвөр, цусны дээж" гэх заалтаар төрийн байгууллага (40 байгууллага) зөвшөөрөл олгож гаалийн хяналтын дор хүний биологийн сорьцыг экспортолсон боловч Засгийн газрын 2017 оны А/407 дугаар тогтоолд дээрх чиглэл тусгагдаагүй байна.

Иймд дээрх үйл ажиллагааг зохицуулж байгаа журам, дүрмийг боловсронгуй болгож, хяналт тавих, цахимд бүрэн шилжүүлэх, шат дамжлагыг багасгах хүрээнд холбогдох төрийн бусад байгууллагаас олгосон экспорт, импортын лиценз, бусад баримт, мэдээллийг гаалийн байгууллага цахимаар ашиглах асуудлыг цэгцлэх зорилгоор Авлигатай тэмцэх газар (АТГ), Цахим хөгжил, харилцаа, холбооны яам (ЦХХХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Гаалийн ерөнхий газар (ГЕГ), Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (ЭЭХХЗГ) зэрэг байгууллагын оролцоог хангасан хэлэлцүүлгийг энэ оны 5 дугаар сард багтаан зохион байгуулж, дээрх журмыг шинэчлэн өөрчлөх тухай саналыг Засгийн газарт хүргүүлэх.

Зөвлөмж 2. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохион байгуулж, ажлын чиг үүргийг оновчтой тодорхойлж, үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх

А/Гаалийн байгууллагад мэргэжлийн хяналтын байгууллагаас хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, хүн, амьтан, ургамлын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авах буюу хүний хөл хориот болон мал амьтны гоц халдварт өвчин хилээр нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэх, экспорт, импортын барааны стандарт, чанарын шаардлагыг хангуулах ажлыг шилжүүлсэн тул албан хаагчид нь ажлын байрны

чиг үүргээс өөр бараа бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийх нөхцөл үүссэнтэй холбоотой чанар, аюулгүй байдалд эрсдэл дагуулж байна.

Иймд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын нэгжийн ажилтнуудыг гаалийн байгууллагын бусад албан хаагчидтай ижил түвшинд ажиллах нөхцөлөөр хангаж, зохион байгуулалтыг оновчтой болгох. Үүнд:

-Хорио цээрийн хяналт хийх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, гааль болон эрсдэлд суурилсан хяналтыг уялдуулах;

-Лабораторийн итгэмжлэлийн хүрээг өргөтгөн аюулгүйн үзүүлэлтийг шинжилдэг болох, түргэвчилсэн аргаар хорио цээрийн үзлэг, шинжилгээ хийх багаж, төхөөрөмжийн хангалт болон аргачлалыг сайжруулах;

-Ариутгал, халдваргүйжүүлэлтийн байгууламж, хадгалалтын онцгой нөхцөл шаардах барааны агуулах болон хилээр нэвтрүүлж буй амьд мал амьтныг үзлэг, шинжилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэх.

Б/Гаалийн төв болон салбар лабораторид 44 ажилтан (*нарийн мэргэжлийн эрдэс, нүүрс, нефть, химийн бодис, хүнсний эрүүл ахуй, нян болон хор судлал, эм, биобэлдмэл, вакцины чанар аюулгүй байдлын шинжээч, химич*) дутагдалтай байгаагаас улсын хилээр нэвтэрч буй зарим бүтээгдэхүүнд чанар аюулгүй байдлын шинжилгээ хийгдэхгүй байгаа нь эрсдэл дагуулж байна;

Иймд хүний нөөцийн стратеги боловсруулан ажилтныг мэргэшүүлэх, дадлагажуулах, ялангуяа хар тамхи, мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын шинжээч, эм, биобэлдмэл, вакцины чанар аюулгүй байдлын чиглэлээр сургах, лабораторийг бүс нутгийн хэмжээнд магадлан итгэмжлүүлэх, лаборант шинжээч нарыг чадавхжуулах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

Лабораторийн ажилтан нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын 4-т заасан хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарч байгаа учир ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаал "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 10 дахь хэсэгт "Цалин хөлс, шагнал урамшуулал" хэсэгт лабораторийн ажилтанд хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл олгох, мэргэжлээс шалтгаалах өвчний хяналтад оруулах зэрэг асуудлыг судалж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Зөвлөмж 3. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, ил тод, нээлттэй болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авах, үр дүнг олон нийтэд мэдээлж хэвших

Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/339 дүгээр тушаал "Гаалийн хяналтын бүсийн журам"-ын 2 дугаар хэсгийн 2.3.13-т "хяналт тавьж ажиллах гаалийн байгууллагаас ирүүлсэн "Өөрийн үнэлгээний хуудас" нь 90 буюу түүнээс дээш оноогоор хангалттай үнэлэгдэж, гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга баталгаажуулсан байх" гэсэн заалт нь ойлгомжгүй бөгөөд зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий нэгжийн удирдлагыг баталгаажилт хийхээр заасан байгааг өөрчлөх нь зүйтэй байна.

Иймд зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг эрхлэх хүсэлт гаргасан ААН-ээс ирүүлсэн төсөл болон урьдчилсан үнэлгээг мэргэжлийн, хөндлөнгийн шинжээч цахимаар үнэлэх, дүгнэлт гаргах зохицуулалтыг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх.

Аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх үйлчилгээ нь эрсдэл өндөртэй ажил учир албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчлийн

тухай мэдэгдэл, тайлбар гаргах журмыг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангаж урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

Хяналт, шалгалтын газар нь тусгай зөвшөөрөл олгох болон хяналт тавих үйл ажиллагааг хамт хэрэгжүүлж байгаа учир үүнд процессын шинжилгээ хийж чиг үүргийг давхардуулахгүй хуваарилж, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх.

Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.3-т *"татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагаас баталсан журмын дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно"* гэж заасан бөгөөд зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид хяналт, шалгалт хийж зөрчил гаргасан тухай мэдээллийг холбогдох нэгжийн тайланд тусгасан байх боловч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан тухай мэдээлэл байхгүй, нисэх буудлын байршил өөрчлөгдсөн ч зарим ААН-ийг сонгон шалгаруулалтгүй шууд үргэлжлүүлэн ажиллуулсан нь ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн гаалийн хяналтын бүс тогтоох зөвшөөрлийг он дамжуулан дунджаар 311 өдөрт шийдвэрлэж хүнд суртал гаргасан, зарим шаардлага хангаагүй байгууллагад богино хугацаанд зөвшөөрөл олгосон зэрэг нөхцөл байдал тогтоогдсон тул эдгээр зөрчлийг арилгах, зөвшөөрөл бүхий ААН-д гүйцэтгэлийн аудит хийж холбогдох арга хэмжээг авч, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.

Зөвлөмж 4. Импортолж буй "электрон тамхинд" гаалийн байгууллагын шийдвэрээр (БТКУС код олгож) зохицуулж байгааг өөрчлөн, холбогдох хуульд тусгах арга хэмжээг авч ажиллах

Монгол Улсын хилээр "электрон тамхи" импортолж буй ААН-үүд онцгой албан татвар төлөлгүй сард ойролцоогоор 40,000 /дөчин мянга/ ширхгийг нэвтрүүлж байгаа нь улсын төсөв болон нийгмийн эрүүл мэндэд эрсдэл дагуулж байна;

Гаалийн байгууллага нь "электрон тамхи" импортлоход Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн тамхи гэсэн ангилалд тусгагдаагүй учир онцгой албан татвар ногдуулаагүй бөгөөд зөвхөн даргын тушаалаар (БТКУС кодоор) зохицуулсан нь эрсдэл дагуулж байгаа учир хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг хүргүүлэх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй байна.

Зөвлөмж 5. Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/295 дугаар тушаал "Гаалийн улсын байцаагчийн цолны журам"-ыг хүчингүй болгох, цолны нэмэгдэл олгосон үйл ажиллагаанд аудит хийлгэж зохих арга хэмжээг авах

Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/295 дугаар тушаал "Гаалийн улсын байцаагчийн цолны журам"-ыг хянаж, дүн шинжилгээ хийхэд зарим заалт нь илт ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэсэн, цолны нэмэгдлийг үндэслэлгүй 40-45 хувиар тогтоосон, цол олгох шаардлагад ажилласан жилээс өөр зааг ялгаа байхгүй, шалгуур үзүүлэлтэд тодорхой тусгасан зохицуулалтгүй, цол бүр нь ижил нөхцөлтэй байгаа учир Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-д *"Захиргааны актын аль нэг хэсэг илт хууль бус бөгөөд тэр нь тухайн захиргааны актыг гаргах гол үндэслэл болж байгаа бол захиргааны акт бүхэлдээ илт хууль бус байна"* гэх заалтыг баримтлан журмыг бүхэлд нь хүчингүй болгох;

Цолны нэмэгдэл олгосон шийдвэр болон уг үйл ажиллагаанд аудит хийлгэж, зөрчлийг арилгах шаардлагатай.

Зөвлөмж 6. Гаалийн байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй (CAIS, CEPS) цахим системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологи, тоног төхөөрөмж хариуцсан нэгжийн үйл ажиллагааг журамлах, хяналтыг сайжруулах

Гаалийн ерөнхий газрын Хяналтын нэгдсэн төв (камерын хяналтын нэгдсэн төв)-ийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж, гаалийн хяналтын цахим систем тасралтгүй байх нөхцөлийг бүрэн хангах, мэргэжлийн хяналтын байгууллагаас шилжиж ирсэн хорио цээрийн чиглэлийн хяналтыг цахим системд нэмж оруулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах асуудал тулгамдаж байна;

Тухайлбал: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн CAIS систем, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн, тээвэр зууч, тээвэрлэгч байгууллагаас гаалийн мэдүүлэг, манифест, тээврийн бүртгэлийг нөхөн бичдэг CEPS систем зэрэг үндсэн үйл ажиллагаанд ашиглаж буй програм, тоног төхөөрөмжийг хүлээж авсан, үнэлсэн, гүйцэтгэлийн чанар зэрэг мэдээлэл, баримтууд архив болон холбогдох нэгжид байхгүй, дээрх системүүд нь мэдээллийн болон технологийн аюулгүй байдал, стандартыг хангаж байгаа эсэх, гаалийн хяналтын үйл ажиллагаанд цаашид ашиглах боломжтой эсэх нь тодорхойгүй байна;

Иймд Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 6.4-т “*Байгууллага нь тагнуулын байгууллагаас баталгаажуулсан мэдээллийн систем, сүлжээ, програм, техник хэрэгслийг төрийн нууцад хамаарах мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагаанд ашиглана*” гэх заалтын дагуу тагнуулын байгууллагаар цахим системдээ эрсдэлийн үнэлгээ хийлгэж, зохих арга хэмжээг авах нь зүйтэй байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР